

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ2023 оны дугаар
сарын -ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Багануурын дулааны станц” ТӨХК-ийн 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 1/481 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Багануур дүүргийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Багануур дүүргийн төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй компани, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Б.Болор-Эрдэнэ/-д даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 382 дугаар тогтоол, 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 523 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ХЭРЭГЛЭГЧДЭД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ**

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м ³	1,487.0
		Төг/ГЖ	23,767.0
2	Багануур ХК-ийн халаалт	Төг/ГЖ	33,234.0
3	Төсвийн байгууллагын халаалт	Төг/м ³	1,549.0
		Төг/ГЖ	29,693.0

2. Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф		
1	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "О"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	845.0		
		Төг/ГДж	11,150.0		
2	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хүний тоогоор	Халаалтын улиралд	Төг/хүн	4,049.0
			Халаалтын бус улиралд	Төг/хүн	5,668.0
		Усны зарцуулалтаар	Төг/м ³	2,089.0	
3	Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф				
3.1	40 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	4,224.0		
3.2	41 м ² -аас 80 м ² хүртэл талбайтай айл өрх	Төг/сар	7,040.0		
3.3	81 м ² -аас дээш талбайтай айл өрх	Төг/сар	14,080.0		